

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР  
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС**

**ИЛТГЭХ ХУУДАС**

Аймгийн Засаг даргын 2021 оны 2 дугаар улиралд бүртгэл хяналтад авсан  
захирамжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн тухай

2021.07. 20

Мандалговь хот

Аймгийн Засаг даргаас 2021 оны 2 дугаар улиралд 69 захирамжийн 112 заалтыг хяналтад авч, Төрийн захиргааны удирдлагын хэлтэс холбогдох сум, хэлтэс, агентлагуудаас биелэлтийг гаргуулан авч нэгтгэн тайланг 2021 оны 7 сарын 08-ны өдөр ирүүлсэн.

Аймгийн Засаг даргын 2021 оны 2 дугаар улиралд хяналтад авсан 69 захирамжийн 112 заалтын Хэрэгжилтийн явцад Засгийн газрын 2020 оны 206 тогтоолын хавсралтаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.3-ын дагуу хяналт шинжилгээ хийхэд 90.8 хувийн хэрэгжилттэй байна. Үүнээс 100 хувь-81, 70 хувь-21, 30 хувь-5, ХБ- 5 заалт байна.

Дүнгээс харахад: Бүрэн хэрэгжсэн буюу 100 хувьтай 81 заалт нь нийт заалтын 72.3 хувийг, хэрэгжих шатандаа буюу 70 хувьтай хэрэгжиж байгаа 21 заалт нь 18.8 хувийг, хэрэгжилт хангалтгүй буюу 30 хувьтай хэрэгжиж байгаа 5 заалт нь 4.4 хувийг, хугацаа болоогүй 5 заалт нь 4.4 хувийг тус тус эзэлсэн байна.

2 улиралд гарсан захирамжуудыг аймгийн цахим хуудсанд 100 хувь байршуулж иргэд мэдээлэл авах боломжийг бүрдүүлсэн.

Мөн 1 улирлын захирамжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийж өгсөн 9 зөвлөмжийн хэрэгжилтийг тооцоход 83.3 хувьтай хэрэгжүүлэн ажиллажээ.

Үүрэг чиглэл болгосон захирамжийн хүрээнд ололттой хэрэгжсэн дараах арга хэмжээнүүд байна. Үүнд:

- “Орон нутгийн хөгжилд иргэдийн оролцоог дэмжих” ажлыг эрчимжүүлж, төрийн үйлчилгээг иргэд олон нийтэд хүнд сурталгүй, шуурхай ил тод хүргэх, үйл ажиллагаандаа иргэдийн оролцоог хангаж ажиллахыг зорьж 7 Хоног бүрийн Бямба гарагийн 11:00-16:00 цагт Аймаг, сумдын Засаг дарга нар иргэдийг тогтмол хүлээн авч, нийт 44 удаагийн уулзалтаар 740 орчим иргэдтэй уулзалт ярилцлага зохион байгуулж, тэдгээрийн санал, хүсэлтийг нь зохих журмын дагуу шийдвэрлэн үйл ажиллагаандаа тусган ажиллаж байна.

2. 2022 оны шинэ хөрөнгө оруулалтын Улсын төсвийн төсөлд тусгах саналыг сүмд, байгууллага, агентлагуудаас нэгтгэн ажлын хэсэг сангийн сайдын Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журмын дагуу хүлээн авч нийт 47 шинэ барилга, байгууламжийн санал ирснээс эрэмбэлж нэгтгэн 28 төсөл арга хэмжээний саналыг цахим системд оруулан яамдуудад албан бичгээр хүргүүлэв.

3. Аймгийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/117 тоот захирамжаар отрын бүс нутгийг тогтоох ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг ГХБХБГ, ХХААГазар болон холбогдох хүмүүсийг оролцуулан байгуулж, ажлын хэсэг хээрийн судалгааны ажлыг гүйцэтгэн Дэлгэрхангай, Сайхан-Овоо, Эрдэнэдалай, Өлзийт сумдын 74,4 мянган га бэлчээрийн талбайд сум дундын отрын бүс нутаг байгуулахаар координат байршлыг тогтоосон. Хээрийн судалгааны ажлаар тогтоосон отрын нөөц талбайд бэлчээрийн экологийн чадавхын зураглал, бэлчээрийн төрөл, төлөв байдлын зураглал, бэлчээрийн даац, ачааллын тооцоо, худаг ус, өвөлжөө хаваржааны байршлыг зураглан гүйцэтгэсэн ажлын тайланг аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаанд хүргүүлсэн.

4. ХХААХҮС-ын 2021 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/76 тушаал, аймгийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/146 захирамжийн дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Адаацаг, Говь-Угтаал, Дэрэн, Дэлгэрцогт, Сайнцагаан, Сайхан-Овоо, Цагаандэлгэр 7-н сумын 20,0 мянган га бэлчээрийн талбайд микробиологийн буюу бактержуулсан будаа цацах ажлыг зохион байгуулж, аймгийн хэмжээнд хээрийн техникийн үр дүн 83.6 хувьтай хийж гүйцэтгэсэн.

5. ХХААХҮЯСайдын 2021 оны 02 дугаар сарын А/45 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 04 дүгээр сарын 16-ны А/150 тоот захирамж, аймгийн ХХААГазрын даргын 04 дүгээр сарын 19-ний А/14 тоот тушаалын дагуу үржлийн малд үзлэг ангилалт хийх ажлын тендер зарлагдан “Уудам жаргалант” ХХК, “Хулд таван эрдэнэ” ХХК, аймгийн “Мал үржүүлэгчдийн холбоо” ТББ шалгарсан. Уг ажлын хүрээнд Баянжаргалан сумын 1000 үхэр, Хулдын Олдохын хүрэн бор омгийн 5000 тэмээ, Сайнцагаан омгийн 5000 хонин сүрэгт хаврын ангилалтын ажлыг технологит хугацаанд зохион байгуулж, эзмэгжүүлэн бүртгэлжүүлэх ажлыг гүйцэтгээд байна.

6. Аймгийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн А/156 захирамжийн дагуу тус аймгийн малчид олноор оторлож буй Дорноговь, Говь-Сүмбэр, Төв, Хэнтий аймгийн 13 суманд тус бүр 1,0 сая төгрөгийг малын сэг зэм устгалаар аймгийн ЗДТГ-аас гаргаж хуваарилан олгосон. Сэг зэм устгалын ажилд сумдын мал эмнэлгийн тасгийн байцаагч нар хяналт тавьж мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажилласан ба сэг зэм устгалын заавар зөвлөмжийг бүх сумдын мэргэжилтнүүдэд хүргэсэн. Мал эмнэлгийн ерөнхий газар, мэргэжлийн хяналтын газраас хяналт шалгалтын баг ажиллан газар дээр нь заавар зөвлөмж өгч тулгамдаж буй асуудлыг уламжлан ажилласан.

7. Ковидын өвчлөл гарсан Эрдэнэдалай, Дэрэн, Өлзийт, Дэлгэрхангай, Сайхановоо, Хулд, Адаацаг мөн盧ус суманд засаг даргын албан бичиг, нөхцөл байдлыг харгалзан Аймгийн Онцгой комиссоос хамгаалах хувцас хэрэглэл, ариутгалын бодис, шинжилгээ оношлуурын зүйлсээр ханган ажиллаж байна. Коронавируст ковид-19 цар тахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд Аймгийн онцгой комисст ирүүлсэн хүсэлт, ор дэлгэх, тусгаарлах байр нэмэгдүүлэх, тоног төхөөрөмж нэмэгдүүлэх бий болгох, хамгаалах хувцас хэрэглэл, ариутгалын бодис, урвалж, шинжилгээний хэрэглэгдэхүүн зэрэг шаардлагатай эд зүйлсийн тооцоо судалгааг гаргаж аймгийн ОНХС-ийн Гамшигийн эрсдлийн бууруулах нөөц хөрөнгөөс 300,0 орчим сая төгрөг, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 84,870.0 мянган төгрөг, төлбөртэй шинжилгээний орлогоос 51,0 сая төгрөг, хандив тусламжаас 196,1 сая төгрөг нийтдээ 632,0 сая төгрөгийн эх үүсвэрийг бурдуулэн сумд, ЭМГ, Нэгдсэн эмнэлэг, Цагдаа, ОБГ-ын үйл ажиллагаанд зарцуулсан байна.

8. 2021 оны 6 сарын 10-ны өдрийн 15 цагаас 6 сарын 15-ны 06 цаг хүртэл АОК-оос тогтоосон "Хатуу хөл хорионы үеэр Засгийн газрын 215 дугаар тогтоол, аймгийн Засаг даргаар батлуулсан "Бүх нийтийн бэлэн байдлын үед гол нэрийн хүнсний болон ахуйн хэрэглээний бараа бүтээгдэхүүнээр түгээлтийн үйлчилгээ үзүүлэх төлөвлөгөө"-ний дагуу Сайнцагаан сумтай хамтран шуурхай зохион байгуулж, Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний нөөц сайтай ААНэгжүүд болох нийт 1 иргэн 8 хүнсний худалдаа эрхлэгчид хүнсний бүтээгдэхүүнийг нийлүүлж, хүргэлт, түгээлтийн үйлчилгээг төрийн 6 байгууллага /ХХААГазар, МЭГ, ГБХЗХгазар, УЦУОШХэлтэс, ГХБХБГазар Сайнцагаан сумын ЗДТГазар/-ын тээврийн хэрэгслээр үйлчилж ажиллалаа.

9. Цар тахалтай холбогдуулан 10 шийдвэр гаргаж хяналтын цэгийг тогтмол ажиллуулан, ариутгал халдвартгүйтгэлийг давхардсан тоогоор 633 байгууллага, ААН-үүдийн 109182 м<sup>2</sup> талбайд хийж, 2564 иргэнээс түргэвчилсэн шинжилгээ авсан.

10. Хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр"-ийг боловсруулан Засаг даргын зөвлөлийн 2021 оны 08 дугаар хуралд танилцуулан хэлэлцүүлэн батлуулж, хөтөлбөрийг 15 сум, хэлтэс агентлагуудад хүргүүлж хэрэгжилтийг ханган ажиллах талаар зөвлөгөө мэдээлэл өгч, аймгийн хүний нөөцлийг хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах 200 сая төгрөгийн төсвийн тооцоог гаргаж ИТХ-аар хэлэлцүүлэхээр бэлтгээд байна.

11. "Дасгал хөдөлгөөн хийцгээ" идэвхтэй хөдөлгөөнийг дэмжих сарын аяныг амжилттай зохион байгуулсан. Аяны хүрээнд дараах арга хэмжээнүүдийг зохион байгуулсан: Үүнд: Алхах-гүйх, Дугуйн унах, Хараа, сонсгол, тулгуур эрхтэний хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд шатрын тэмцээн, Өсвөр насны хүүхдийн дунд гар зургийн болон шүлгийн уралдаан, Идэвхтэй дасгал хөдөлгөөнөөр хичээллэж байгаа иргэдийг витаминжуулах өдөрлөг Тавин ус эмийн сан/ "Иогоор хичээллээ" сэдэвт 10 видео хичээлийн цуврал сургалт, "Идэвхтэй хөдөлгөөн ба суугаа хэв маяг", "Шагайт дасгал" сэдэвт үндэсний уламжлалт тоглоом наадгайн танин мэдэхүйн цахим сургалтыг зэргийг тус тус зохион байгуулсан.

Төрийн болон төрийн бус байгууллагуудад Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас хэвлэн гаргасан “Дасгал хөдөлгөөн, хөдөлгөөний хомсдол”, “Эрч хүч дасгал хөдөлгөөнийг нэмэгдүүлэх арга зүйн багц”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг засан сайжруулах арга зүйн зөвлөмж, сургалтын модуль” зэрэг номыг тарааж, иргэдийг мэдээ мэдээллээр хангасан. Тус сарын аяны хүрээнд нийт 479 иргэн алхалт-гүйлтийн цахим аплекешин Страва ашиглан, алхалт гүйлтийн төрөлд 10,475 км замыг, дугуй унах аянд нэгдсэн иргэд 2,935 км замыг тус тус туулсан байна. Аянд Биеийн тамир, спортын газар, Цаг уур орчинь шинжилгээний газар, Аймгийн Засаг даргын Тамгын газар, Аймгийн ИТХурал, Онцгой байдлын газар, Музей, аймгийн Эмэгтэйчүүдийн холбоо, ЭМГазар, МСҮТөв, Мандал сургууль, ГИЦСургууль, ТТХТеатр, ГБХЗХГазар, Ахмадын хороо, 3,4, 6-р цэцэрлэг, 3-р сургууль, ХХААГазар, Мал эмнэлэг, Аймгийн шүүх, ХААН банк, Монгол банк, ГАН-ИЛЧ ХХК, Мандал худалдааны төвийн хувиараа хөдөлмөр эхлэгчид, Сайнцагаан сумын 5,6,7,8,9 дүгээр багийн иргэд, Өндөршил, Баянжаргалан, Луус, Сайхан-Овоо, Гурвансайхан, Цагаандэлгэр, Хулд, Эрдэнэдалай зэрэг 9 сум, 25 байгуулага, аж ахуйн нэгж нэгдэн оролцсон.

12. Аймгийн 2021-2024 оны Стратеги төлөвлөгөөг боловсруулан батлуулж, аймгийн стратеги төлөвлөгөөг үндэслэн аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар хэлтэс, агентлагууд стратеги төлөвлөгөөгөө боловсруулан батлуулсан.

13. Насан туршийн боловсролын төвийн сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийг 2021 оны 06 сарын 07-оос эхлэн 4 жилийн хугацаатай олгуулан, ирэх 2021-2022 оны хичээлийн жилээс эхлэн төв өөрөө сургалт зохион байгуулан насанд хурэгчдэд гэрчилгээ олгох зөвшөөрөлтэй болсон бөгөөд үйл ажиллагаа өргөжин, тогтвожиж ажиллах боломжийг бүрдүүлсэн.

14. Сумдын Засаг даргын Тамгын газрын 2020 оны үйл ажиллагааны үр дүнг үнэлж өгсөн нийтлэг зөвлөмжийн явцад хяналт шинжилгээ хийж, цаашид хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар арга зүйн зөвлөмж өгсөн.

#### Цаашид анхаарах асуудал, зөвлөмж

1. Зах зээл бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл, ОНХСангийн хөрөнгөөр Гурвансайхан-4, Говь-Угтаал-3, Өндөршил-2, Сайнцагаан-1 нийт 10 инженерийн хийцтэй худаг гаргах тендер шалгаруулалтад “Экогое” ХХК, Өлзийт, Өндөршил сумдад баригдах мал угаалгын 4 ванны тендер шалгаруулалтад “Юбибижи” ХХК, өвс тэжээлийн агуулах барих тендер шалгаруулалтад “Хос соёмбөт өргөө” ХХК нь тус тус гүйцэтгэгчээр шалгарч гэрээ байгуулсан боловч ажил эхлээгүй байгаа тул хяналт тавих ажлыг эрчимжүүлэх

2. Аймгийн төвийн 0,4кв-ын хуваарилах сүлжээг 100 хувь шинэчлэх, хэрэглэгчдийн цахилгаан эрчим хүчний тоолуурыг ухаалаг тоолуураар солих ажлын гүйцэтгэл дээр орон нутгийн зүгээс хөндлөнгийн хяналт тавьж, гүйцэтгэх явцад гарсан тулгамдаж буй асуудлыг газар дээр нь шийдвэрлэн гүйцэтгэгч байгууллага болох “Проект

ватт" ХХК-тай хамтран ажиллаж, хамгаалалтын зурvas тогтоох ажил эхлээгүй байгаа тул анхаарч ажиллах

3. Удирдах ажилтнуудын шуурхай цуглааныг цахим хэлбэрээр зохион байгуулах боломжийг судлан шийдвэрлэх

4. 2021 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжигдэх зураг, төсөв боловсруулах ажлыг эрчимжүүлэх

5. Хедөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас бүтэн жилээр тооцон гаргаж, удаашралтай байгаа заалтыг эрчимжүүлэх арга хэмжээ авч ажиллах

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан хэрэгжилтийг З улирлын захирамжийн хэрэгжилттэй хамт ирүүлэх

Илтгэх хуудас бичсэн:

Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн  
ахлах мэргэжилтэн



Э.Одончимэг